ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ДОА-2021/140/СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2021 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Нармандах<br>Утас: 7058-4207, Цахим хаяг:narmandakhd@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |

## Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ....9
3. Аудитын тайлан ....10
3.1. Ерөнхий зүйл ....10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ....10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт....10
3.4. Материаллаг байдал ....10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ....12
3.7. Шилэн дансны мэдээлэл....12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....13
3.9. Аудитын илрүүлэлт....13
Залруулсан алдаа ....13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил....13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд....13
4. Менежментийн захиадал ....13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт....15

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.24 № 216

танай ______ -ны № ______ -т

ДАШБАЛБАР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ Б.АЛТАНЦЭЦЭГ
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дашбалбар сумын Эрүүл мэндийн төв 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр 82.6 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **51,196,676.11** | **62,833,787.03** |
| **33** | **АВЛАГА** | - | 68,468.00 |
| **335** | **Бусад авлага** | - | 68,468.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 68,468.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 51,196,676.11 | 62,765,319.03 |
| **351** | **Түүхий эд материал** | 767,631.11 | 3,988,844.03 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | - | 1,255,200.00 |
| 35130 | Эм боох материал | 767,631.11 | 2,733,644.03 |
| **354** | **Хангамжийн материал** | 20,888,045.00 | 28,465,475.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 261,700.00 | 440,550.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 19,811,345.00 | 25,504,145.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 815,000.00 | - |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 2,185,380.00 |
| 35460 | Хүнсний материал | - | 335,400.00 |
| 35600 | Мал амьтад | 29,541,000.00 | 30,311,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **542,362,648.47** | **1,128,718,220.06** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 542,362,648.47 | 1,128,718,220.06 |
| 391 | Газар | | |
| **392** | **Биет хөрөнгө** | 523,938,648.47 | 1,110,294,220.06 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 467,644,743.58 | 989,076,587.58 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (20,364,498.84) | (40,728,997.68) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 33,610,165.00 | 74,810,165.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (33,610,165.00) | (17,976,831.66) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 193,264,225.06 | 221,197,258.06 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (146,486,701.70) | (162,605,577.82) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 26,372,391.50 | 37,192,391.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (19,332,694.31) | (20,676,077.38) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 557,400.00 | 4,537,400.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (82,976.82) | (115,176.78) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 53,420,590.00 | 64,244,133.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (31,053,830.00) | (38,661,053.76) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 18,424,000.00 | 18,424,000.00 |
| 39301 | Програм хангамж | 862,540.00 | 862,540.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (862,540.00) | (862,540.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 18,424,000.00 | 18,424,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **593,559,324.58** | **1,191,552,007.09** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **68,468.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 68,468.00 |
| **413** | **Өглөг** | - | 68,468.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 68,468.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 68,468.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **593,559,324.58** | **1,191,483,539.09** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 593,559,324.58 | 739,613,392.34 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 451,870,146.75 | 451,870,146.75 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (112,229,141.41) | 485,695,073.10 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (112,229,141.41) | (112,229,141.41) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 597,924,214.51 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 253,918,319.24 | 253,918,319.24 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **593,559,324.58** | **1,191,552,007.09** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **469,032,611.36** | **1,169,896,401.66** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **40,225,711.36** | **662,667,367.66** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 40,225,711.36 | 622,040,567.66 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,000,000.00 | 12,887,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,000,000.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 12,887,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 14,900,000.00 | 589,499,720.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 23,325,711.36 | 19,653,847.66 |
| **122** | **Тусламжийн орлого** | - | 40,626,800.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | - | 40,626,800.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **428,806,900.00** | **507,229,034.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 416,067,700.00 | 487,133,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 416,067,700.00 | 487,133,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,942,800.00 | 6,323,900.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,942,800.00 | 6,323,900.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 10,796,400.00 | 13,771,434.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 10,796,400.00 | 13,771,434.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **476,875,220.47** | **570,252,187.15** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **476,875,220.47** | **570,252,187.15** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 472,092,287.59 | 569,618,163.46 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 301,237,147.00 | 357,679,511.00 |
| 210101 | Үндсэн цалин | 223,820,257.00 | 249,285,593.00 |
| 210102 | Нэмэгдэл | 37,728,909.00 | 64,406,043.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,643,000.00 | 6,733,000.00 |
| 210104 | Урамшуулал | 33,044,981.00 | 37,254,875.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 37,771,787.77 | 46,510,443.82 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,055,137.47 | 32,401,970.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,059,236.23 | 3,811,995.11 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,447,388.98 | 2,948,795.44 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 564,547.73 | 667,971.13 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,645,477.36 | 6,679,711.28 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 16,034,448.00 | 17,148,135.28 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,365,208.00 | 4,767,919.28 |
| 210302 | Түлш, халаалт | 12,602,540.00 | 12,280,216.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 66,700.00 | 100,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 17,424,197.00 | 19,709,296.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 867,878.00 | 686,242.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,149,655.00 | 13,395,440.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 347,760.00 | 157,720.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,499,610.00 | 2,218,694.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,559,294.00 | 3,251,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 43,789,036.83 | 61,209,228.62 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 35,789,426.83 | 50,648,128.62 |
| 210502 | Хоол, хүнс | 7,999,610.00 | 10,561,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,591,500.00 | 6,147,320.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 52,800.00 | 48,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,538,700.00 | 6,099,320.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,338,600.00 | 3,048,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,338,600.00 | 3,048,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,841,300.00 | 2,787,875.33 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 360,000.00 | 518,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 81,675.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 86,500.00 | 108,133.33 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 77,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 600,000.00 | 871,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 15,252.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 794,800.00 | 1,116,615.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 49,064,270.99 | 55,378,353.41 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,600,007.00 | 4,745,505.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 43,464,263.99 | 50,632,848.41 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4,782,932.88 | 634,023.69 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 220,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 220,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,782,932.88 | 414,023.69 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,782,932.88 | 414,023.69 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(7,842,609.11)** | **599,644,214.51** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 13,084,000.00 | 1,720,000.00 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | 13,084,000.00 | 1,720,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (13,084,000.00) | (1,720,000.00) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(20,926,609.11)** | **597,924,214.51** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **430,806,900.00** | **507,229,034.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,000,000.00** | - |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,000,000.00 | - |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 2,000,000.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,000,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **428,806,900.00** | **507,229,034.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 416,067,700.00 | 487,133,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 416,067,700.00 | 487,133,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,942,800.00 | 6,323,900.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,942,800.00 | 6,323,900.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 10,796,400.00 | 13,771,434.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 10,796,400.00 | 13,771,434.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **427,311,900.00** | **507,229,034.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **427,311,900.00** | **507,229,034.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **422,528,967.12** | **506,595,010.31** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 301,237,147.00 | 357,679,511.00 |
| 210101 | Үндсэн цалин | 223,820,257.00 | 248,808,238.58 |
| 210102 | Нэмэгдэл | 37,728,909.00 | 64,883,397.42 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,643,000.00 | 6,733,000.00 |
| 210104 | Урамшуулал | 33,044,981.00 | 37,254,875.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 37,771,787.77 | 46,510,443.82 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,055,137.47 | 32,401,970.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,059,236.23 | 3,811,995.11 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,447,388.98 | 2,948,795.44 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 564,547.73 | 667,971.13 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,645,477.36 | 6,679,711.28 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 14,317,168.00 | 19,333,515.28 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,365,208.00 | 4,767,919.28 |
| 210302 | Түлш, халаалт | 10,885,260.00 | 14,465,596.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 66,700.00 | 100,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 17,463,661.00 | 18,453,121.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 466,636.00 | 1,040,347.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,149,655.00 | 13,395,440.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 347,760.00 | 163,320.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,499,610.00 | 2,254,494.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,000,000.00 | 1,599,520.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 38,725,099.35 | 45,436,793.88 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 28,745,489.35 | 32,960,293.88 |
| 210502 | Хоол, хүнс | 7,999,610.00 | 10,896,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,980,000.00 | 1,580,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,703,800.00 | 8,637,600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 503,800.00 | 1,001,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,200,000.00 | 7,636,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,338,600.00 | 3,048,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,338,600.00 | 3,048,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,612,000.00 | 2,972,230.33 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 360,000.00 | 518,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 81,675.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 86,500.00 | 108,133.33 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 77,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 600,000.00 | 871,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 15,252.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 565,500.00 | 1,300,970.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,359,704.00 | 4,523,795.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,359,704.00 | 4,523,795.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,782,932.88** | **634,023.69** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 220,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 220,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,782,932.88 | 414,023.69 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,782,932.88 | 414,023.69 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **3,495,000.00** | **-** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **3,495,000.00** | - |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **3,495,000.00** | - |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 3,495,000.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 3,495,000.00 | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(3,495,000.00)** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 451,870,146.75 | 253,918,319.24 | -112,229,141.41 | 593,559,324.58 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **451,870,146.75** | **253,918,319.24** | **-112,229,141.41** | **593,559,324.58** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | 0.00 |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **451,870,146.75** | **253,918,319.24** | **-112,229,141.41** | **593,559,324.58** |
| D01 | **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **451,870,146.75** | **253,918,319.24** | **-112,229,141.41** | **593,559,324.58** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **451,870,146.75** | **253,918,319.24** | **-112,229,141.41** | **593,559,324.58** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 597,924,214.51 | 597,924,214.51 |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **451,870,146.75** | **253,918,319.24** | **485,695,073.10** | **1,191,483,539.09** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 500,941,300.00 | 500,491,110.31 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 500,941,300.00 | 500,491,110.31 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 500,721,300.00 | 500,271,110.31 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 357,826,900.00 | 357,679,511.00 |
| 210101 | Үндсэн цалин | 217,051,200.00 | 248,808,238.58 |
| 210102 | Нэмэгдэл | 101,750,000.00 | 64,883,397.42 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,468,000.00 | 6,733,000.00 |
| 210104 | Урамшуулал | 32,557,700.00 | 37,254,875.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46,540,000.00 | 46,510,443.82 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,750,400.00 | 32,401,970.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,447,400.00 | 3,811,995.11 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,757,900.00 | 2,948,795.44 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 689,500.00 | 667,971.13 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,894,800.00 | 6,679,711.28 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,587,600.00 | 19,333,515.28 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,550,000.00 | 4,767,919.28 |
| 210302 | Түлш, халаалт | 14,937,600.00 | 14,465,596.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 100,000.00 | 100,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,054,100.00 | 18,053,121.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 908,400.00 | 908,347.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,165,700.00 | 13,127,440.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 180,000.00 | 163,320.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,200,000.00 | 2,254,494.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,600,000.00 | 1,599,520.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 40,036,800.00 | 40,036,793.88 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 30,456,800.00 | 30,456,793.88 |
| 210502 | Хоол, хүнс | 8,000,000.00 | 8,000,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,580,000.00 | 1,580,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,637,600.00 | 8,637,600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,001,600.00 | 1,001,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,636,000.00 | 7,636,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,050,000.00 | 3,048,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,050,000.00 | 3,048,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,988,300.00 | 2,972,230.33 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 518,200.00 | 518,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 81,700.00 | 81,675.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 110,000.00 | 108,133.33 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 77,000.00 | 77,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 871,000.00 | 871,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 18,400.00 | 15,252.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,312,000.00 | 1,300,970.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,000,000.00 | 3,999,895.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,000,000.00 | 3,999,895.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 220,000.00 | 220,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 220,000.00 | 220,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 220,000.00 | 220,000.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **0** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **6,323,900.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **6,323,900.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 6,323,900.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 400,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 132,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 268,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **5,400,000.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,503,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 2,896,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **523,900.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 523,900.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 6,323,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 6,323,900.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Д.Даш танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 20-оос 2021 оны 02 дугаар сарын 23–ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах хариуцаж хэрэгжүүлэв.

Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнх иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг иргэдэд хүргэх,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дашбалбар сумын Эрүүл мэндийн төв нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 570,252.2 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 11,405.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

## 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 597,924.2 мянган төгрөгөөр буюу 1 дахин өссөн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | 68.5 | 68.5 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 51,196.7 | 62,765.3 | 11,568.6 |
| Үндсэн хөрөнгө | 542,362.6 | 1,128,718.2 | 586,355.6 |
| **Нийт хөрөнгө** | **593,559.3** | **1,191,552.0** | **597,992.7** |
| Өр төлбөр | - | 68.5 | 68.5 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 593,559.3 | 1,191,483.5 | 597,924.2 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **593,559.3** | **1,191,552.0** | **597,992.7** |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл байхгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 68.5 мянган төгрөг болж өссөн нь хөгжлийн бэрхшээлтэй ажилтнаас ХХОАТ суутган тооцсоноос шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэл 68.5 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 62,765.3 мянган төгрөг болж 11,568.6 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор худалдан авалт хийсэнтэй холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,128,718.2 мянган төгрөг болж 586,355.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Эмнэлгийн барилгын өргөтгөл шинээр ашиглалтад хүлээн авсан, мөн аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар автомашин, тоног төхөөрөмж, өргөтгөлийн барилгын ашиглалттай холбоотой сумын иргэдийн хандив тусламжаар автомашин, тавилга, тоног төхөөрөмж хүлээн авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө тээврийн хэрэгсэл акталсан 20,800.0 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна..

Биет бус хөрөнгийн дансанд гүйлгээ хийгдээгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 68.5 мянган төгрөг болж өссөн нь хөгжлийн бэрхшээлтэй ажилтнаас ХХОАТ суутган тооцсоноос шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,191,483.5 мянган төгрөг болж 597,924.2 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 700,863.8 мянган төгрөгөөр буюу 2.5 дахин өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 93,377.0 мянган төгрөгөөр буюу 19.6 хувиар өссөн байна.. Энэ нь ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолоор цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй байна.

### 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 500,941.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 500,941.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг хэвээр баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 500,941.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 500,941.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 500,941.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 500,905.1 мянган төгрөгийг зарцуулан 36.2 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 500,905.1 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны захирагчаас 6,323.9 мянган төгрөгийн орлогыг авч бичиг хэрэгт 132.0 мянган, шатахуунд 268.0 мянган, хоол хүнсэнд 2,896.5 мянган, бусад бараа үйлчилгээний зардалд 523.9 мянган, нийт 6,323.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### 3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 3 мэдээлэл, хугацаа хоцроон байршуулсан байна. Хөрөнгийн орлогын 67,100.0 мянган төгрөгийн мэдээллийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулаагүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд итгэл үзүүлсэн байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 12,331.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 68,5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 12,262.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар залруулга хийгдээгүй болно.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар үйл ажиллагаатай холбоотой 68.5 мянган төгрөгийн зөрчилд 1, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 67,100.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос 68,468 төгрөгийн татвар суутган авсан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “дараах орлогыг албан татвараас чөлөөлнө”, 22.1.2-т “хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого”, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д "хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Албан шаардлага хүргүүлэв.

2. Хөрөнгийн 67,100.0 мянган төгрөгийн орлогыг www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Албан шаардлага хүргүүлэв.

#### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 12,262.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос татвар суутгаан тооцсон байна. Энэ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*Дотоод хяналттай холбоотой асуудал*

*1.1.* *Илрүүлэлт:* Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй үлдэх өртөггүй, ашигладаггүй 862.5 мянган төгрөгийн санхүүгийн программ хангамж байна.

*1.2.* *Эрсдэл:* Хөрөнгийн үнэ цэнэ алдагдах

*1.3.* *Өгсөн зөвлөмж:* УСНББОУС - 17 мөрдөж ажиллах.

*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

*2.Дотоод хяналттай холбоотой асуудал*

*3.1. Илрүүлэлт:* Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 11,400.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэлд дахин үнэлгээ хийгээгүй байна.

*3.2. Эрсдэл*: Хөрөнгийн үнэ цэнэ алдагдах

*3.3. Өгсөн зөвлөмж* УСНББОУС - 17 мөрдөж ажиллах.

*3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | Дашбалбар сумын ЭМТ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2020 | | | ДОА-2021/140/СТА-ТШ3 |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Дашбалбар сумын ЭМТ | | Мянган төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 4 | Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос татвар суутган авсан | 68.5 | Албан шаардлага | Нягтлан бодогч | Б.Баатарцогт |
| | Хөрөнгийн орлогыг www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулаагүй байна. | 67,100.0 | Албан шаардлага | Нягтлан бодогч | Б.Баатарцогт |
| 5 | Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй үлдэх өртөггүй, ашигладаггүй санхүүгийн программ хангамж байна. | 862.5 | Зөвлөмж өгөв | Нягтлан бодогч | Б.Баатарцогт |
| | Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тээврийн хэрэгсэлд дахин үнэлгээ хийх. | 11,400.0 | Зөвлөмж өгөв | Нягтлан бодогч | Б.Баатарцогт |
| **ДҮН** | | **79,431.0** | | | |